



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/529

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улс, Оросын холбооны Улс, Хятад Улсын хооронд олон улсын чанартай соёл, боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэх, нийгмийн өндөр хариуцлагатай, соёл танин мэдэхүйн аялал, зуучлалын өргөн мэдлэг, чадвартай хүнийг хүмүүжүүлэх зорилгоор зохиогдож байгаа “Агуу их цайны зам дээр” олон улсын хүүхдийн урлагийн наадмын 2 дугаар шатанд оролцох сурагчдын замын зардалд 650,000 (зургаан зуун тавин мянган) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 650,000 (зургаан зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101126

Аймгийн Засаг даргын 2021 оны...¹⁰
дугаар сарын ...²⁰...ны өдрийн...^{17/2021}
дугаар захирамжийн хавсралт



“АГУУ ИХ ЦАЙНЫ ЗАМ ДЭЭР” ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН
VIII УРАЛДААНД ОРОЛЦОГЧДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	ӨВ-УБ хооронд явах шатахуун	л	220	2500	550000
2	Жолоочийн албан томилолт	3 хоног	1	100000	100000
	Нийт				650000

-оОо-